В.И.ЛЕНИНИЙ МЭНДЭЛСНИЙ 100 ЖИЛД

# В.И. ЛЕНИН БА МАТЕМАТИК

Дэлхийн хөдөлмөрчдийн аугаа их жолоодогч, суут багш В.И.Ленин математик (тооны ухаан)-ыг амьдралынхаа туршид амтархан сонирхдог байжээ.

Лениний эцэг физик математикийн багш байсан бөгөөд өөрийнхөө хүүхдүүдийн математик үзэл санааны хөгжлийн төлөө маш их анхаардаг хүн байсан учир В.И.Ленин аавынхаа шууд удирдлагын дор математикийг бүр бага наснаасаа эхлэн жинхэнэ ёсоор сурч эхэлсэн байна.

В.И.Лениний ах Александр, эгч Анна нар ч мөн математикт дур сонирхолтой, математикаар байнга хичээллэдэг байжээ.

Ах Александраас гэртээ ирүүлсэн захидалд: «Аавдаа, таны маш их хүсдэг байсан „Математикийн софизм“ гэдэг товхимолыг явуулав.

Миний бодоход Володя чи хэрэв эдгээр софизмын учрыг бие дааж олбол энэ нь онц их ашигтай ч байж болох юм» гэж бичсэнээр гэр бүлээрээ математикт гойд сонирхдог байсан нь нотлогдож байна. В. И. Ленин гимназид суралцаж байхдаа ангидаа тэргүүний сурлагатан байсан бөгөөд ялангуяа математикийн талаар гарамгай сурч байжээ.

В.И.Ленинтэй нэг ангид сурч байсан М.Ф. Кузнецов «Володя бол математикийн хичээлд их дуртай, нөхөддөө дуртайяа тусалдаг байсан бөгөөд түүний санаачлагаар математик сонирхогчдын анхны дугуйлан байгуулагдан хичээллэсэн бөгөөд уул хичээл нь амжилттай явагдаж байв» гэжээ.

Симбирскийн гимназын захирлын гарын үсэгтэй тодорхойлолтонд «В.И.Ленин бол авъяас билгээр сайн, ажилд шийдэмгий махруун оролдлоготойгоос гадна математикт бусдаасаа гарамгай их амжилт үзүүлж чадахаа харуулсан юм» гэж онцлон тэмдэглэсэн байна.

В.И.Ленин зөвхөн өөрөө математикийг мэддэг, түүнийг амьдралынхаа туршид сонирхож байсан төдийгүй харин сургуулиудад математик заалтыг сайжруулах, математикийн хичээлийн агуулга сурах бичигт болон заах аргыг дээшлүүлэх асуудалд онцгой их анхаарал тавьдаг байв. В.И.Ленин математикийн талаар программ, сурах бичгийн чанарт байнга анхаарал тавьж байсныг түүний хувийн номын санд математикийн анхны сурах бичгээс гадна засварлан хэвлэсэн сурах бичиг олон байсан явдал нотлон харуулж байна. Н.К.Крупская заах аргын хүн болохоороо математик сургалтын талаар асуудал боловсруулахдаа В.И.Лениний зөвлөлгөөг авдаг байжээ. Ингэж аугаа их удирдагч В. И. Ленин математикаар маш их сонирхон хичээллэж байсан нь манай залуучууд, өсвөрийн үеийнхэнд үлэмжийн сайхан үлгэр дууриал болж байна.

**Д. Баатар**



*Жаргалантын сангийн аж ахуйнхан тариагаа цайруулж байгаа нь:*
М. Цэрэндоржийн авсан гэрэл зураг

МАСТЕРУУДЫН ЗӨВЛӨЛГӨӨНИЙ ӨМНӨ

# *БРИГАДЫН ДАРГЫН ИДЭВХ ЗҮТГЭЛ*

Намсрайн төрсөн газар нь Сүхбаатар аймгийн Уулбаян суманд бий. 1958 оны намар МАХН-ын илгээлтээр ирж аймгийн Барилга угсралтын конторт ажилчнаар орж ажилласнаас хойш арван жил өнгөрчээ.

Намсрайд анх ажил нь хүнд нүсэр, мэдэхгүй чадахгүй зүйл олонтоо тохиолддог байсан ч анд нөхдийнхөө ач, мэргэжилтэн хүмүүсийн туслалцаа, дэмжлэг, өөрийн идэвх зүтгэлээр удаж төдөлгүй ажилдаа дадлагажиж норм төлөвлөгөөгөө ч тогтмол биелүүлдэг болсноор барахгүй 2-3 хос мэргэжил эзэмшиж авчээ.

Жирийн барилгачнаас нэгдсэн бригадын дарга хүртэл дэвшин ажиллаж байгаа энэ хүн сүүлийн 5 жилийн хугацаанд сар улирал, жилийн төлөвлөгөөг 105—140 хувиар биелүүлж олон арван залуу барилгачдад мэргэжил олгож,тэргүүний хүмүүсийн эгнээнд хүргэсэн байна.

Зуунмод хотын төвд баригдсан 24, 36 айлын орон сууц, зочид буудал, Намын Хороо, АДХГ Захиргааны өргөтгөл, нэгдүгээр цэцэрлэг зэрэг олон арван барилгыг барьж байгуулахад гар бие оролцон зохион байгуулсан хүн.

—Манай бригад аймгийн нэгдсэн больницын барилга дээр ажиллаж байна. Социалист уралдааныг бригад, ажилчдын хооронд өрнүүлэн, ажлын цагийг үр бүтээлтэй өнгөрүүлэхэд, хүн бүрийг хөдөлмөрийн багаж, хэрэгсэл, ажиллах нөхцлөөр бүрэн хангахад гол анхаарлаа тавьж ажилласны үр дүнд хөдөлмөрийн бүтээмж нэмэгдэж нийт ажилчид сар, улирлын төлөвлөгөөгөө тогтмол биелүүлж байна.

—Барилгачдын мэргэжил,мэдлэгийг дээшлүүлэхэд бүлгэм дугуйланг тогтмолжуулж жил бүр мэргэжил ахиулах шалгалт авснаар одоо бригадын ажилчдын 70 шахам хувь нь 3-4 төрлийн мэргэжил эзэмшив.

—Шинээр техник мэргэжлийн сургууль төгссөн хүмүүсийг ахмад ажилчдыг дагалдуулан тэдэнд богино хугацаанд дадлага эзэмшүүлж байна гэж МАХН-ын гишүүн Намсрай ярив. Ажлыг хугацаанд нь чанар үзэмжтэй хийхийн тулд юуны өмнө ажлаа тодорхой төлөвлөж, урьдчилан сайн бэлтгэсний үндсэн дээр уг ажилдаа ордог энэ бригадын хамт олон 9 дүгээр сарын төлөвлөгөөгөө давуулан биелүүлж, барилга конторын хэмжээнд социалист уралдаанд тэргүүн байранд явaa нь бригадын даргын идэвх зүтгэл, зохион байгуулах арга барилтай салшгүй холбоотой юм.

**Н.Нанжид**

# ЗУУНМОД ХОТ

Хөдөлмөрчдийн амьдрал, соёлын эрэлт хэрэгцээг улам сайжруулж байх нь манай социалист нийгмийн байгууллын гол зорилт мөн.

Ард түмнийг суурьшуулж, хот суурин газруудыг соёлжуулан тохижуулах талаар нам засгаас их анхаарч байгаагийн үр дүнд хориодхон жилийн түүхтэй Зуунмод хот богино хугацаанд танигдашгүй болон хөгжиж үйлдвэр, соёл, үйлчилгээний шинэ шинэ салбар нэмэгдэж, нийтийн тохилог орон сууц баригдан, нийгэм ахуйн үйлчилгээ дээшилсээр байна.

Зөвхөн 4 дүгээр таван жилд 12 худалдагчтай дэлгүүр, 24 айлын орон сууц 2, цементийн агуулах, намын хорооны өргөтгөл, өндөр хүчдэлийн шугам, хүүхдийн амбулатори, хүнсний комбинатын улаан булан, 100 тонны багтаамжтай ногооны зоорь зэрэг олон барилга байгууламжууд буй болсны дээр одоо 120 ортой нэгдсэн больниц, мал эмнэлгийн ариун цэврийн станцын барилга баригдаж байна.

Зуунмод хотыг тохижуулах төлөвлөгөө ёсоор энэ онд нилээд зүйлүүд биелэгдэж байна.

Зарим уурын зууханд машинаар ус зөөдөг байсныг сувгаар дамжуулах болгож, 24, 36 айлын усан системийн шугамыг засварлаж, зочид буудлыг халуун устай болгов.

Мөн аймгийн Намын Хороо, АДХГ Захиргаа аж ахуйн аргаар найман айлын сууцууд барьж байна. Аймгийн Холбооны газар зурагт радиогийн дахин дамжуулах станц барьж ашиглалтанд оруулав.Мөн бусад албан байгууллагууд ажилчдын хүчээр контор, гарааш засварлаж их ойнуудыг угтсан гудамжны самбар лоозун зэрэг нилээд зүйлүүдийг хийв.

Хотын соёлжилт, тохижилт болон, албан байгууллагуудын ажиллах хэвийн нөхцлийг хангахад цахилгаан эрчим хүч, радио, телефон харилцаа, хот нийгэм хангамж, үйлчилгээний байгууллагууд голлох рольтой.

Зуунмод хотод өндөр хүчдэлийн цахилгаан шугам тавигдаж, үйлдвэр үйлчилгээ, айл өрх бүрийг цахилгаанаар бүрэн хангах сайхан боломжтой боллоо.

Хотын цахилгаан шугам сүлжээг байнга хянаж засварлах, түүнийг хайр гамтай эдлэн цахилгаан хэрэглэх журмыг нарийн биелүүлж байх нь нийт албан байгууллага, оршин суугч иргэдийн ариун үүрэг мөн.

Хотын хэмжээнд радио цэг 700 байхаас 620 гаруй ажиллаж байна. Малчдын хороо, барилгын ажилчдын нэгдсэн орон сууц зэрэг газруудад радио цэг тавигдаагүй байгааг зохих байгууллагууд анхаарвал зохино.

Гуч гаруй албан газар 2900 шоо дөрвөлжин метрийн ашигтай талбай бүхий орон сууцны нэгдсэн халаалт, усан систем, зочид буудал, халуун ус, усан тээвэр зэрэг чухал үйлчилгээг хариуцсан хотын нийгэм хангамжийн товчооны үүрэг роль улам өндөржиж байна.

Хангамжийн товчооны харъяа ихэнх газрууд хагас жилийн дүнгээр нэр төрөл, орлогын төлөвлөгөөг амжилттай биелүүлсэн боловч, цэвэр ус, хог тээвэр, орон сууцны орлогын төлөвлөгөө тасалджээ. Мод тарих, зүлэг суулгах ажил Зуунмод хотын төвд хоцрогдонгуй байгаа тул хойшид мод тарилтыг чанаржуулах хэрэгтэй байна.

Гудамж талбайг тэгшлэх,нэгдсэн болон хувийн хашааг жигд үзэмжтэй болгох, гудамжны нэр, хаалганы дугааруудыг шинэчлэх, ашиглагдахгүй болсон байшинг буулгах, нэгдсэн байрнуудын орчныг тохижуулах, авто хөсгийн хөдөлгөөний урсгал чигийг тогтоож, зохих тэмдгүүдийг байрлуулах, гудамж талбайг цэвэрлэх зэрэг ажлууд удаашралтай байна.

Хот тохижуулах хоёр жилийн хугацаанд энэ ажлыг эрхлэн хариуцах хотын комисс байгуулж, төлөвлөгөөг нарийвчлан, байгууллага бүрд гүйцэтгэх ажлыг тодорхой өгч биеийн хөдөлмөрийн цагийг үр бүтээлтэй болгож, гүйцэтгэлийг тухай бүрд нь дүгнэдэг журам тогтоовол зохино.

Хотод оршин суугчдын бүртгэл судалгааг нарийн болгож, хотын хэмжээгээр зохиогдож байгаа нийтийг хамарсан үзэл суртал, аж ахуйн ажилд бүх хүмүүсийг бүрэн хамарч байхын тулд хороо, орон сууц гудамжны зөвлөл, ахлагчдын ажлыг тогтмолжуулах нь чухал.

Хүн бүрийн идэвх чармайлт, социалист уралдааныг өрнүүлэн түүхт ойнуудыг угтсан үзэл суртал, зохион байгуулалтын ажлын эрч хүч, үр дүнг дээшлүүлэх нь Зуунмод хотын нам, төр, олон нийтийн байгууллагуудын эрхэм зорилт болж байна.

**Хотын намын хорооны нарийн бичгийн дарга Ш.Доржпалам**

# Архангайнхан ингэж ажиллаж байна

## Архангай аймгийн намын байгууллагын ажилтнууд манай аймагт ...

Архангай аймгийн Намын Хорооны нэгдүгээр нарийн бичгийн дарга Ш. Цэрэвсамба ахлагчтай тус аймгийн намын байгууллагын ажилтнууд энэ сарын 5, 6, 7—ны өдрүүдэд Монгол—Зөвлөлтийн найрамдлын сарын ажлыг тохиолдуулан Заамар сумын «Заамар» нэгдэл,Жаргалантын САА—гаар явж, Зөвлөлт Холбоот Улсын хүч хөрөнгөөр барьж байгуулагдсан нэгдлийн төвийн барилга байгууламж, соёл үйлчилгээний газар, сууръ бригадын тохижилттой танилцаж туршлага судалсан юм.

Архангай аймгийн бүх сум—нэгдэл, САА—н дэргэдэх намын үүр, хороодын нарийн бичгийн дарга нар оролцсон тус аймгийн намын байгууллагын ажилтнуудын дунд Хайрхан сумын намын хорооны нарийн бичгийн дарга, Ардын Их Хурлын депутат Бадарч, Хангай сумын намын хорооны нарийн бичгийн дарга,МАХН—ын Төв Хорооны орлогч гишүүн Далхаа, Өндөр-улаан сумын «Бадрал» нэгдлийн намын хорооны нарийн бичгийн дарга Раднаа нарын зэрэг дадлага туршлагатай тэргүүний хүмүүс оролцлоо.

Архангай аймгийн намын байгууллагын ажилтнуудыг Заамар сумын «Заамар» нэгдэл, Жаргалантын САА-н намын байгууллагын туршлагатай танилцахад аймгийн Намын Хорооны нэгдүгээр нарийн бичгийн дарга Ш. Агваансодов оролцов.



*Намын байгууллагын ажилтнууд харилцан туршлага солилцож байгаа нь: Зураг дээр: (Зүүн гараас) Архангай аймгийн Түвшрүүлэхийн САА—н Ц.Жамбалсүрэн, Ихтамир сумын Л. Чойжилсүрэн, Өндөр—улаан сумын Б. Раднаа,Төв аймгийн Жаргалантын САА—н Н. Дашням, Цэцэрлэг хотын АДХГ Захиргааны дарга С. Рэгзэндагва нар*

## ЗУУТЫН ХӨДӨЛГӨӨН

Архангай аймгийн намын байгууллагууд В.И.Ленинийн мэндэлсний 100 жилийн ойг угтаж, ажлын салбар бүрт зуутын хөдөлгөөнийг өрнүүлэн ажиллаж, улс ардын аж ахуйн төлөвлөгөөт зорилтыг биелүүлэх ажилдаа бахдам сайхан амжилт гаргаж байгаа тухай аймгийн Намын Хорооны нэгдүгээр нарийн бичгийн дарга Ш. Цэрэнсамбын ярианаас тодорхой харагдаж байна.

### Зуун хувьтан

Их ойнуудыг угтсан хөдөлмөрийн ээлжинд хүн бүр, байгууллага бүхэн зуун хувьтны эгнээнд хамрагдаж, төлөвлөгөөт зорилтоо зуугаас дээш хувь биелүүлсэн байхаар социалист уралдаанд үүрэг амлалт авч дотоод нөөц бололцоогоо дайчлан ажиллаж, амжилтанд хүрч байна.

Аль сум—нэгдэл, ямар байгууллага, өгөгдсөн төлөвлөгөөт зорилтыг хугацаанд нь биелүүлнэ тэр байгууллагын ажлын амжилтыг нийтэд сурталчилж, зуутын хөдөлгөөнийг улам эрчимжүүлэх зорилгоор аймгийн сониндׅ«Хүндэт самбар» ажиллуулж, төлөвлөгөөг хамгийн түрүүнд биелүүлсэн эхний таван байгууллагад баяр хүргэдэг болсон нь хаана ямар амжилт гарч, аль байгууллага ажлаараа түрүүлж яваag олон түмэн соргогоор хүлээн авч, тэдний амжилтанд хүрэхийн төлөө чармайн ажилладаг байна.

Юуны өмнө гүйцэтгэгч хүн бүрт зохиож байгаа ажлынхаа гол зорилтыг бүрэн ойлгуулсны үндсэн дээр ажлаа явуулдаг болсон нь хөдөлмөрийн өндөр бүтээмжтэй ажиллах эх сурвалж болдог ажээ.

### Зуун мянган мал нэмнэ

Зуутын хөдөлгөөний нэг хэлбэр нь түүхт ойнуудыг угтаж 1969, 1970 онуудад аймгийнхаа мал сүргийг зуун мянган толгойгоор өсгөнө гэсэн зорилт тавин ажиллаж байгаа явдал юм.

Энэ зорилтоо биелүүлэхийн тулд төлийг хүлээн авах бэлтгэлийг сайтар хангаж малчдын мал маллах арга ажиллагааг сайжруулан төл бүрийг мал болгохын төлөө тэмцэн ажиллаж байна.

Төлийг бүрэн бойжуулахын үндэс болсон эх малыг тарга хүч авахуулах, өвлийн бэлтгэлийг сайн хангах, хашаа саравч, худаг усыг дулаалах, өвс тэжээлийг хүрэлцэхүйц бэлтгэх ажлыг бүх нийтийн хөдөлгөөн болгон өрнүүлж байна.

### Зуун шинэ зүйл

Зуун хувьтны хөдөлгөөний бас нэг хэлбэр бол байгууллага, сум—нэгдэл бүхэн зуун шинэ зүйл хийж бүтээхээр сэтгэн бодож, шамдан ажиллаж байгаа явдал юм.

Энэ хэлбэр нь түүхт ойнуудыг угтаж үйлчилгээний ажлыг сайжруулах, ажилдаа шинэ сэргэг зүйлийг бүтээлчээр нэвтрүүлэх, юмхнаар юм хийж дотоод нөөц бололцоогоо дайчлан ажиллахад чиглэгдсэнээрээ хөдөлмөрчин олны анхаарлыг гойд татаж, хүн бүр байгууллагатаа нэгэн шинэ зүйлийг хийж бүтээхийг эрмэлзэж байгаа явдал юм.

Жишээлбэл: Аль нэгэн сумын төвд ашиглалт, тохижилт нь муу, халуун усны газар байлаа гэхэд түүнийг тохижуулж үйлчилгээг сайжруулсан байвал нэг шинэ зүйл хийсэнд бүртгэх юм.

Түүнчлэн байгалийн баялагийг ашиглах, шинэ зүйл санаачлах, хөдөлмөр хөнгөвчлөх, дэвшилттэй зүйлийг ажил үйлсдээ нэвтрүүлэх зэрэг нь цөм нэг шинэ зүйлд тооцогдоно. Ийнхүү дуслыг хураавал далай болно гэгчээр нэг шинэ зүйлээс сэдэвлэж, байгууллага бүр зуун шинэ зүйлийг бүтээсэн байх юм.

### Юмаар юм хийж сурья

Архангайнхан их ойнуудыг угтаж „цагаан идээ, модон эдлэл хийх талаараа үлгэр жишээч ажиллая“ гэсэн хөдөлгөөн өрнүүлж байна.

Хүн бүр мужааны багаж хэрэгслэлтэй болж, түүнийгээ эзэмшиж, гэр ахуйн хэрэгцээт зүйлийг өөрсдөө урлан хийх юм.

### Тэргүүн туршлага

Заавал нэвтрүүлэх туршлагыг зурагт ухуулан хуудас болгон олшруулж уул туршлагыг эзэмшүүлэх, хүн бүрт хүргэж, түүний туршлагыг хэрхэн яаж эзэмших талаар аргачилсан зөвлөлгөө өгөн ажилладаг байна.Саалийн хугацаанд нутгийн үүлдрийн монгол үнээ нэг бүрээс 1018 литр сүү саасан Өндөр—улаан сумын „Бадрал“ нэгдлийн саальчин, Ардын Их Хурлын депутат Л. Дэнсмаагийн туршлагыг арваад үзүүлэлтээр товч бичиж өөрий нь зургийг тавьж ухуулах хуудас болгоод бүх саальчдад тараажээ.

Энэ хуудсандаа аврага саальчин Дэнсмаагийн туршлагыг 1969 онд үнээний суурь бүрт нэг саальчинд, 1970 онд хоёр саальчинд эзэмшүүлнэ.

Аймгийн бүх саальчин Дэнсмаагийн нэг үнээнээс саасан сүүний 50 хувь буюу 500 литр сүү сааж чадвал аймгийн хэмжээгээр улсад жил бүр 7 сая литр сүүг илүү тушаана гэж бичжээ.

Ингэж тэр хүний туршлагыг эзэмшихэд аль болохоор нөлөө үзүүлж болох аргыг хайж, уншихад хялбар, том үсгээр өргөдсөн, үргэлж нүдэнд нь харагдаж,алив нэгэн зүйлийг бодогдуулахаар хийгдсэн авсаархан ийм ухуулах хуудас зохих ач холбогдлоо үзүүлдэг байна.



*Архангай аймгийн намын байгууллагын төлөөлөгчид Заамар сумын «Заамар» нэгдлийн төвийн байдалтай танилцаж байгаа нь.*

Энэ нүүрийг „Үнэн“ сонины тус аймаг дахь сурвалжлагч П.Жанчив бэлтгэв.

## Цүнхээр мөнгө тушаагчдын хариуцлага

Аймгийн банкны хэлтсийн кассын төлөвлөгөөний бүх орлогын 70—85 хувь нь цүнхээр тушааг-даж байна.

Цүнхээр мөнгө тушаагчид улсын их хэмжээний хөрөнгө хариуцан хамгаалдаг үүрэгтэй билээ.

Гэтэл зарим хүмүүс хайнга хандан мөнгөнд тавих хяналтыг сулруулж, хариуцлага алдах явдал гаргаж байна.

1969 онд аймгийн хэмжээний орлого тушаагч байгууллагуудын касс,дэлгүүр, гуанзангуудаас зөрчил гаргаагүй цэг ховор байгаагийн гадна мөнгөн тэмдэгтийг толгойлохгүй бүслэх, дэвсгэрийг хольцолдуулах, олс утсаар боож мөнгөн тэмдэгтийг хайр гамгүй тасдах, дагавар хуудсыг бүрдэл дутуу бичих, тоог баллан засах, урагдсан, цоорсон цүнхээр мөнгө хүргүүлэх, батлагдаагүй тэмдэг хэрэглэх, нэг тэмдэгийг хэд хэдэн хүн дамжуулан хэрэглэх зэрэг зөрчлүүдээс хураагдсан мөнгийг цаг тухайд нь орлого болгоход саатах явдал үргэлжилсээр байна.

Энэ онд Зуунмод хотын дэлгүүр гуанзангуудаас 199 удаа 10132 төгрөгийн илүүдэл, 6241 төгрөгийн дутагдал, сумдын ХБ—ийн ангиудаас 73 удаа 9362 төгрөгийн илүүдэл, 1222 төгрөгийн дутагдал, үйлдвэрийн хол бооны артель, эмийн аптекаас 5 удаа 1242 төгрөгийн илүүдэл, 972 төгрөгийн дутагдал тус тус гарч байжээ.

Энэ нь кассын сахилга бат, мөнгө хариуцагчдын хариуцлага, түүнд тавих хяналт шалгалтын ажил сул байгаатай холбоотой юм. Нөгөө талаар Сайд нарын Зөвлөлийн 1969 оны 56 дугаар тогтоолоор батлагдсан кассын ажиллагааны дүрэм журмыг судлаж ажилд ёсчлон нэвтрүүлэх ажил муу байгааг харуулж байна.

Банканд цүнхээр мөнгө тушаагч байгууллагууд дээрх дутагдалд дүгнэлт хийж, мөнгө тушаагчдын ажлын хариуцлагыг сайжруулан нэгч мөнгөний зөрчилгүй ажиллах талаар анхаарч ажиллах явдал чухал байна.

**Ц. Далхаа**

### 1969-1970 ОНЫ ӨВӨЛ, ЗУУНМОД ХОТОД ЯВАГДАХ ХҮМҮҮЖЛИЙН АЖЛЫН ЦАГИЙН ХУВААРЬ

**ДАВАА.**

1. Нам, эвлэлийн улс төрийн сургууль 19—21 цаг

**МЯГМАР.**

1. Эмэгтэйчүүдийн гэр ахуйн дугуйлан 13—15 цаг
2. Ажилчид үйлдвэрчний эвлэлийн сургууль 19—21 цаг
3. Орос хэлний сургууль 19—22 цаг
4. Ерөнхий боловсролын оройн сургууль 19—23 цаг

**ЛХАГВА**

1. Эмнэлэг гэгээрлийн сургууль $7^{30}$—$8^{30}$ цаг
2. Албан газрын лекцүүд 19—20 цаг
3. Орос хэлний сургууль 19—22 цаг
4. Ерөнхий боловсролын оройн сургууль 19—23 цаг

**ПҮРЭВ**

1. Ерөнхий боловсролын оройн сургууль 19—23 цаг
2. Нам, олон нийтийн байгууллагын хурал 19—21 цаг
3. Ард түмний соёлын сургууль 20—23 цаг
4. Орос хэлний сургууль 19—21 цаг

**ЛЕНИНИЙ СУГАР ГАРИГ**

1. Улс төрийн сонсгол $7^{30}$—8 цаг
2. Нам, эвлэлийн гишүүдийн ба нийтийн лекц 19—21 цаг
3. Багш нарын лекц 14—15 цаг
4. Ерөнхий боловсролын оройн сургууль 19—23 цаг
5. Суртал нэвтрүүлэгчдийн семинар 15—16 цаг

**БЯМБА**

1. Ухуулагчдын семинар 12—13 цаг
2. Үзвэрүүд 19—21 цаг

**НЯМ**

1. Олон нийтийн ажлууд

ТАЙЛБАР. Биеийн тамирын төрөл бүрийн секцүүд Мягмар, Лхагва, Пүрэв гаригуудад 21 цагаас мөн Бямба, Ням гаригт зарим секц хичээллэнэ.

**Намын Хорооны Үзэл суртлын хэлтэс**

*ЗХУ—ын улаан армийн тухай киноны 7 хоногт*

## СЫНЫ ОТЕЧЕСТВА

(ЗХУ—ын уран сайхны шинэ кино)

Зохиолч С. Азимов, Н. Рожков нар зохиож, найруулагч Л. Файзиевын найруулгаар энэ киног 1968 онд «Узбекфильм» кино үйлдвэрт бүтээжээ.

Эх орны дайны сүүлийн жилүүдэд Германы үхлийн хорих газар Шпильхаузенд хоригдож байсан 26 эрэлхэг баатруудын мөнх дурсгалд энэ киног зориулжээ.

Кино: Эх орны дайнаас хойш 20 гаруй жилийн дараа Узбекийн Бухар хотод Шпильхаузены хорих лагериас олдсон нэр үл мэдэгдэх зураачийн уран бүтээлээр үзэсгэлэн байгуулахаар баруун Германы зураач Культшер ирж байгаагаар эхлэнэ.

Үзэсгэлэнд тавигдсан бүтээлийн дээж болгож хоригдлын хувцасны ар дээр зурсан нэгэн эх орончийн зураг төвийн сониинд хэвлэгдэнэ.

Дайнд яваад ор сураггүй алга болсон Искандер Салимовын эхнэр Ельна Салимова уул зургийг өөрийн нөхрийн хөрөг гэж таниад Культшертэй очиж уулзана.

Культшер өөрөө Шпильхаузенд хоригдож байсан тул болсон явдлыг сайн санаж байлаа.

Тэрээр хөрөг дээр зурагдсан хүнийг Марк Гельц гэдэг еврей хүн, харин зургийг нэгэн хэлгүй узбек хүн зурсан гэж хэлнэ.

Культшерийн зөвлөсөн ёсоор одоо баруун Германд амьдарч байгаа, Шпильхаузены хорих газрын гэрэл зурагчин байсан Хильда Хайнц гэдэг эмэгтэйтэй уулзахаар явна. Хильда Хенц Еленагийн нөхрийг эх орноосоо урвасан этгээд мэтээр хэлнэ.

Нөхрийнхөө ариун сайхан нэрийг бузарлахыг хүсээгүй учир цаашид эрэл сурлаа үргэлжлүүлсээр байлаа.

Нэгэн өдөр Еленатай зөвлөлтийн цэргийн хошууч ирж уулзах ба тэр хүн Шпильхаузены хорих газарт лалын шажны уншлага хийдэг лам болон зүс буруулж эх орончдын нууц байгууллагыг удирдаж байжээ.

Мулла Батыров, Еленад болсон үнэн явдлыг ярьж өгнө.

Зөвлөлтийн армийн командлал, Германы фашистууд зэвсгийн нууц үйлдвэр газар дор байгуулж байгааг мэдэж авчээ.

Тэр үйлдвэрлэлийн бүдүүвч зургийг олж ирэх үүргийг Батыров, Салимов нарт өгчээ.

Тэр хоёр дайсанд бууж өгч улмаар хорих газарт ажиллах ёстой байлаа.

Энд хоригдож байсан фашизмыг эсэргүүцэгч германы эх орonч залуу Марк Гельцын зураг зурах авъяасыг ашиглан уул бүдүүвч зургийг зуруулж авна.

Марк Гельц зурсан зургаа хоригдлын хувцасныхаа дотор талд оёсон байлаа. Салимов түүний хувцсыг тайлан авч өөрийн хувцсыг тайлж өгснөөр Марк Гельц узбек хэлгүй залуу Искандер Салимов болсон юмсанжээ.

Салимов өөрийн итгэлтэй хоёр нөхрийн хамт хорих газраас оргоно.

Дайснууд араас нь нэхэн хөөхөд Салимов даавуун дээр зурсан зургаа нөхөртөө өгч явуулаад дайсныг төөрөгдүүлэн өөрөө баригдан улмаар загалмайд тэлүүлж зэрлэгээр алагдаж байна.

Салимовын нөхөр пуужингийн нууц үйлдвэрийг устган баатарлагаар амь үрэгдсний дотор Марк Гельц оржээ.

Ингээд дайнд амь үрэгдсэн зөвлөлтийн дайчдын дурсгалын хөшөөний нээлт болж самбар дээр И. Салимов, М. Гельц нарын нэрийг сайхан сийлсэн байх нь харагдана.

Энэ кинонд Искандер Салимовт Н. Шашик—Оглы, Марк Гельцийн дүрд В. Керенев нар тоглож байна.

## *Хөхөөгийн бригадынхан*

Улаан толгойн өвөлжөөнд өвс нуруулдаж байгаа хэсэг залуучууд дээр очив.

Идэр насныхаа гал дөлөөр шалмаг ажиллаж байгаа залуусыг харахад үнэхээр сэтгэл хөдлөм ажээ.

Жил бүр Батсүмбэрийн САА-д ирж ажилладаг, УБДС—ийн олон зуун оюутны зөвхөн нэг бригадын ажилтай танилцсан юм. Оюутнуудын бригадын ахлагч Р. Хөхөө гэдэг сэргэлэн бор залуу:

—Манай бригад 8 дугаар сарын 14-нд ирсэн. Одоогийн байдлаар 10247 бухал хийж 139,7 га газрын өвс тармаж, өвөлжөөн дээр 2 нуруу хийж дуусгаад байна.

Орос хэлний 1 дүгээр ангийн оюутан Цэцгээ 126 га газрын өвс тармасны гадна биеийн тамирын ангийн оюутан Очирваань ганцаараа 1200 бухал хийж бусдыгаа манлайлав. Энэчлэн оюутан Ганболд, Цэрэндорж нар өдөр тутмын нормоо тогтмол 104—116 хувиар биелүүлж гялалзсан амжилт гаргаж байна гэж ярилаа.

**Л. Батсүх**
**Д. Долгормаа**

### *НОГООЧДЫН АМЖИЛТ*

Архустын САА-н ногоо бригадын Бадамдорж ахлагчтай СХТБ—ын хамт олон энэ онд хураах идэшний ногоогоо амжилттай хурааж дуусав.

Төмс 45 тонн хураахаас 62 тонн буюу 127 хувь, байцаа, манжин, сонгино хураах төлөвлөгөөг 120—150 хувиар биелүүллээ.

Энэ ажилд ногоочин Өлзийбуян, Рэнцэнханд, Цэнд, Аюуш, Доржпалам нар болон Анагаах ухааны дунд сургуулийн сурагчид онц идэвх зүтгэлтэй ажилласны гадна СХТБ—ын гишүүн Өлзийбуян хариуцсан талбайгаасаа 18 тонн байцаа авч төлөвлөгөөгөө 150 хувиар биелүүлжээ.

**Л. Пунцагсүрэн**



МОНГОЛ ХҮН МОРИНД ДУРТАЙ
Л. Дамдиндоржийн авсан судалбар зураг

Хариуцлагатай нарийн бичгийн дарга П. Очирбат

(Х—00778) «Анхдугаар таван жил» сонины үйлдвэрт хэвлэв